



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"ХЭЛЭЛЦСЭН нь: Дахин төлөвлөлтийн тухай

Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд барилга (контор) нэрээр бүртгэлтэй, 90002428 бүртгэлийн код бүхий 299,310,026.90 (хоёр зуун ерэн есөн сая гурван зуун арван мянга хорин зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 49,885,004.40 (дөчин есөн сая найман зуун наян таван мянга дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, барилга нь газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй, зарим бүтээц хийцүүд хэсэгчлэн аваарын байдалд байгаа нь Барилгын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тухай Хот Байгуулалт, хөгжлийн газар, барилгын чанар аюулгүй байдлын хэлтсийн паспорт СБД-05-21-АТГ судалгаа, дүгнэлтэд тусгасан байна.

Төрийн өмчийн үр ацгийг нэмэгдүүлэх, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа дээрх объектыг дахин төлөвлөлтөд хамруулан тухайн газар дээр зөвхөн Авлигатай тэмцэх газрын оффисын барилгыг шинэчлэх, шинэ барилга барьж байгуулах тухай хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй конторын зориулалттай 249,425,022.50 (хоёр зуун дөчин есөн сая дөрвөн зуун хорин таван мянга хорин хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй барилгыг дахин төлөвлөлтөнд оруулах асуудлыг дэмжээд зураг төсөв боловсруулах, шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг санал, төсөл боловсруулан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР